



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/167

Хажуу шинэ-Ус

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.4, 48.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.3 дахь хэсэг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Хажуу Шинэ Ус худгийг сэргээн засварлах” ажил 19,948,500.00 (Арван есөн сая есөн зуун дөчин найман мянга таван зуу) төгрөгийн үнийн санал ирүүлсэн Т.Бадралт-төгөлдөр ахлагчтай “Эвсэл” иргэний бүлэгтэй шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. “Хажуу Шинэ Ус худгийг сэргээн засварлах” ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг “Эвсэл” иргэний бүлгийн ахлагч (Т.Бадралт-төгөлдөр)-т даалгасугай.

3. Т.Бадралт-төгөлдөртэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401067